


## АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР


Нийслэлийн Өмчийн харилцааны газрын eDoc программд 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1813 албан бичиг ирсэн байна. Үүнээс Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 5, байгууллагаар бүртгэгдсэн 229, eDoc системээр бүртгэгдсэн 1579 албан бичиг байна. Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 98,19% - тай байна. Үүнээс:

- Хариутай албан бичгийн тоо 211 ба шийдвэрлэлтийн хувь 97.87%
- Хариугүй албан бичгийн тоо 1602 ба шийдвэрлэлтийн хувь 99.47% байна. Үүнийг графикаар харуулбал:

Хариутай ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



Хариугүй ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



Edoc системээр болон хэвлэмэл байдлаар ирсэн албан бичгийн бүрдлийн шаардлага хангагдахуйц байдалд хяналт тавин, шаардлага хангаагүй албан бичгийг буцааж ахин ирүүлэх арга хэмжээг авч ажилласан. Мөн хүлээлгэн өгсөн хүний гарын үсгээр баталгаажуулан ирсэн баримт бичгийн бүртгэлд тэмдэглэж цаг тухай бүрт нь Edoc системд бүртгэн оруулж байна.

Явуулах баримт бичгийг хүлээн авч албан бичгийн стандарт, хавсралт, явуулах хаягийн бүрэн, зөв эсэхийг шалган, тамга, тэмдэг дарах, бүртгэж дугаарлах, дугтуйлах, хаяглах, шуудангийн салбарт хүлээлгэн өгөх ажлыг журмын дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байна.